



Бэлчээрийн ургамал хамгаалах ТӨСӨЛ Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын СБАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 1 САР 01 2021 ОНЫ 12 САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨГ: 5,000,000

Төсөл хэрэгжсэн газар

Хөвсгөл аймаг Улаан-уул сум
Бэлтэс, Хорон тал БАХ

Төслийн зорилго

Тусгай хамгаалалттай газрын орчны бүс нутаг малын бэлчээрт ургадаг нэн ховор болон ховор эмийн ургамлыг малчдын оролцоотой хамгаалах, хадлангийн ургамлыг нэмэлтээр тарьж ургуулах

Төслийн зорилтууд

Бэлтэс, Хорон тал БАХ-ийн бэлчээрт ургадаг нэн ховор болон ховор /вансэмбэрүү, чонын хэл, алтайн сонгино, ванчингарав, их бага саадган цэцэг гэх мэт/ ургамлыг хамгаалах талаар малчид, иргэдэд мэдээлэл хийх, сургалт зохион байгуулах

Үйл ажиллагаа

Төсөл хэрэгжих Шивлэг багийн малчид нь жилийн 4 улиралд нүүдэл хийн бэлчээрээ сэлгэж ашигладаг онцлогтой. Хорьдол Сардагийн нурууг даван урд бие Шивлэг, Бэлтэс, Хорон талын

голуудад өвөлжиж хавар 3 сарын 15-ны дотор нүүдэл хийн Ууржуул, Өлийн даваагаар даван Хорьдолын ар талаар хаваржиж малаа төллүүлдэг. Намар 10 сарын 15-аас хойш өвөлжөөндөө буудаг учраас бэлчээр ашиглалт сайтай гол голоороо Шивлэг багийн малчид БАХ-ийн зохион байгуулалтанд нэгдэн орж чадсан.

Бэлтэс БАХ малчин Б.Дамдинсүрэн, Б.Лхагвасүрэн, Б.Ганзориг нарын 200 гаруй эмийн ургамал ургадаг хадлангийн талбайгаа өнжөөж, хөлийн бууцанд ногоон гэжээл тариалж нэмэлтээр хадлан авах боломжийг нэмэгдүүлж хамтын хүчээр хадлангаа хураалаа

Шивлэг, Бэлтэс БАХ-ийн малчдад АБАХ, СБАХ хамтран бэлчээр сэлгэх өнжөөх талаар мэдээлэл хийх, бэлчээрийн эмийн ургамал хамгаалах сургалт зохион байгуулж, гарын авлага тараасан.

Улаан тайгын УТХГ-ын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч Р.Даваадалай, Мэргэжилтэн Г.Мягмаррагчаа нарын хамтаар Вансэмбэрүү ургаж

ус тогтох үед бэлчээрт ургадаг вансэмбэрүүд эргүүл хяналт хийж ажилласан.

Бөөстөгийн рашаанчид очих үед байгаль хамгаалагч О.Бямбаа, малчин Б.Дамдинсүрэн нарыг эргүүл хяналтаар ажиллуулж Рашааны ойролцоох 100 гаруй га талбайн эмийн ургамлыг хамгаалж тодорхой үр дүнд хүрлээ.

Малчин Б.Ганзориг, СБАХ М.Отгонбаатар нар зэрлэг сонгино үрээ боловсруулах үед хадланчидаас хамгаалах эргүүл хяналтыг тогтмол хийж ажиллаа бэлчээрт ургадаг зэрлэг сонгиныг хугацаанд түүлгэх, нарин өврийн сонгиныг түүлгэхгүй байх арга хэмжээг авч ажиллаа.

Сонгинтын сонгины үрийг авч хамгаалж буй бэлчээрт тариалалт хийлээ.

Төслийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	3,000,000
СБАХ	2,000,000
Нийт	5,000,000



Зураг-1 Хадлан хураалт



Зураг-3 Шивлэг, Бэлтэс БАХ сургалт



Зураг-5 Бөөстөг рашаан эргүүл



Зураг-2 Хадлан хураалт



Зураг-4 Эргүүл хяналт



Зураг-6 Зэрлэг сонгино тариалалт

Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт, төг
1	Хадлан бэлтгэх шатахуун зардалд	литр	303	1,650	500,000
2	Сургалтын зардалд	удаа	2	400,000	800,000
3	Эргүүл хяналт томилолт	Хүн	3	200,000	600,000
4	Урамшуулал	Хүн	3	200,000	600,000
5	Сонгино тариалалт томилолт	Хүн	2	200,000	400,000
6	Сонгино тариалалт шатахуун зардалд	литр	60,6	1,650	100,000
7	Малчин хөдөлмөр эрхлэлт	3 хүн	3 сар	420,000	3,780,000
	Нийт				6,780,000

Борлуулалт, үйлчилгээний орлого

Зэрлэг сонгино шинээр суулгаснаар тухайн ургамлын тархац нэмэгдэх сайн тал бий болж байна. /үнэлэх боломжгүй/

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Ногоон тэжээл /портер/	машин	2	500,000	1,000,000
	Нийт				1,000,000

ТӨСЛИЙН ҮР ДҮН

- Байгаль хамгаалах үйл ажиллагаанд малчид, БАХ, СБАХ оролцоог сайжруулах, хамтын оролцоотой бэлчээрийн эмийн болон нэн ховор ургамал хамгаалах замаар бэлчээрээ зүй зохистой ашиглаж сурах
- Бэлтэс, Хорон тал БАХ-ийн бэлчээрт ургадаг Цохь, Сонгинт, Нарийн гуя зэрэг газруудын зэрлэг сонгиныг хамгаалж үлдэх малчид иргэд зэрлэг сонгиныг зүй зохистой ашиглаж сурах
- Бэлчээрийн эмийн ургамлыг хамгаалсанаар ургамлын нөөцийг нэмэгдүүлэх сайн талтай
- Малчид ногоон тэжээл тариалсанаар нэмэлтээр хадлан тэжээлээ бэлтгэх, хадлангийн талбайгаа хамгаалах
- УТХГ, байгаль хамгаалагчид СБАХ, БАХ, малчдын хамтын ажиллагаа сайжирна
- Бэлчээрийн сэлгэлтийг цаг тухайд хийж хэвшнээр бэлчээр нутагаа хамгаалж хариуцлагатай малчин болоход суралцах

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

- Орон нутгийн малчид, нутгийн иргэд

Тайлан гаргасан: СБАХ тэргүүн /М.Отгонбаатар/